

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709  
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ  
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.14

### Онцлох мэдээ

- АНУ-ын хэрэглэгчийн төлөв байдал 2-р сарын эхээр сүүлийн 10 гаруй жилийн доод түвшинд хүрчээ. Ойрын хугацаанд инфляц үргэлжлэн өсөх хүлээлт байгаа хэдий ч илүүдэл хадгаламжтай энэ үед хэрэглээ буурах магадлал бага байна. Мичиганы Их сургуулийн (U Mich) хэрэглэгчийн төлөвийн индекс урьдчилсан байдлаар 61.7 гарч 2011.10-р сараас хойш доод түвшинд очлоо.
- ОХУ-ын төв банк Баасан гарагт бодлогын хүүгээ огцом өсгөж 9.5% болгосон бөгөөд зээлийн зардлыг 100 суурь нэгжээр 2 удаа дараалж өсгөөд байна. Тус улс 2021 онд бодлогын хүүгээ 4.25%-иас 7 удаа өсгөсөн хэдий ч инфляцийг тогтоож чадахгүй байгаа юм.

### Валютын зах зээл

Арилжаачид Европт дайн болох эсэх ирмэгт тулж, инфляц өссөөр байгаа нь ам.доллар болон эрсдэл багатай валютуудыг өсгөн эсрэгээр эрсдэл ихтэй валютууд зүтгэхэд хүндрэл тулгарав. Украйнд учирч болзошгүй дайны нөлөө еврогийн ханшийг өнгөрсөн долоо хоногийн дээд цэг 1.1495-с 1.136 хүртэл унагалаа. Австрали, Шинэ Зеланд долларууд өнгөрсөн долоо хоногийн түвшнээс доогуур арилжаалагдаж байгаа бол рубль Баасан гарагийн огцом уналтын дараа сулраад байна. Харин эрсдэл багатай иен 115.50 хүрч 116.34 цэгээс чангарчээ. Хөрөнгө оруулагчид Английн төв банк ирэх сард бодлогын хүүгээ 40%-ийн магадлалтайгаар 50 суурь нэгжээр өсгөнө гэж тооцоолоод байгаа бөгөөд фунт 1.3567-р арилжаалагдаж байна. Шинэ Зеланд доллар 0.1% суларч 0.6645 хүрсэн бол Австрали доллар 0.714 орчимд эргэлдэж байна.

### Алтны зах зээл

Даваа гарагт алтны ханш өмнөх арилжааны өдөр хүрсэн 3 сарын дээд байр сууриа хадгаллаа. Украйныг тойрсон асуудал алтны эрэлтийг барьсаар хэвээр байна. Өглөөний байдлаар 1 унц алтны спот ханш 1,859.16 ам.доллар байлаа. Баасан гарагийн арилжаагаар 2021 оны 10 сараас хойших нэг өдрийн хамгийн их өсөлт үзүүлж 11 сарын 19-нөөс хойших хамгийн өндөр 1,865.15 ам.долларт хүрсэн юм. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.9% өсөж 1,859.00 ам.доллар хүрээд байна.

### Зэсийн зах зээл

Газрын тосны үнийн өсөлт хөрөнгө оруулагчдыг инфляцийн эсрэг хэдхэн хүргэж улмаар дэлхийн эдийн засгийг хөдөлгөгч гэгддэг зэсийн ханш өнөөдөр өслөө. Гэсэн ч ам.долларын ханш чангаралттай байгаа нь улаан металлын ханшийн өсөлтийг хязгаарлаж байна. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.5% дээшилж 9,909 ам.долларт арилжаалагдаж байгаа бол

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1345	-0.04%		
USD/CNY	6.3622	-0.16%		
USD/RUB	77.1771	0.02%		
USD/JPY	115.47	0.04%		
USD/KRW	1199.65	0.10%		
AUD/USD	0.7118	-0.01%		
GBP/USD	1.3542	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	34738.1	-1.43%		
S&P 500	4418.6	-1.90%		
NASDAQ	13791.2	-2.78%		
FTSE 100	7661.0	-0.15%		
Nikkei 225	26970.3	-2.62%		
DAX	15425.1	-0.42%		
Hang Seng	24620.7	-1.15%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1854.77	-0.21%		
Мөнгө	23.68	0.41%		
Нүүрс (Чин хуанг дао)	165.82	0.00%		
Зэс (LME)	9860.5	-3.84%		
Төмрийн хүдэр	784.50	-5.88%		
Газрын тос (NYME)	94.7	1.72%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.19%	54.51%		
US 3M LIBOR	0.51%	28.26%		
US 6M LIBOR	0.84%	26.49%		
US 12M LIBOR	1.39%	23.81%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.96%	1.07%		
UK Treasury 10Y	1.55%	1.38%		
GE Treasury 10Y	0.30%	4.58%		
JP Treasury 10Y	0.21%	-9.09%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.13%	0.11%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.41%	0.07%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.29%	-0.12%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.97%	0.00%
ММС	9.25%	4/15/2024	23.36%	-1.26%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.18%	-0.16%
Номад	5.13%	4/7/2026	4.70%	0.02%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.96%	-0.11%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.38%	-0.19%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.03%	0.01%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	20.51	2.19%
Mongolian Mining Corp	2.11	2.93%
Erdene Resource Dev	0.43	3.66%
Centerra Gold	10.85	3.53%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

### Ханшийн таамаглал

Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

### Түүхий эд

Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
US U Mich Sentiment Prelim	61.7	67.5	67.2
GE HICP Final YY	5.1%	5.1%	5.1%
UK GDP Prelim YY	6.5%	6.4%	6.8%
UK GDP Prelim QQ	1.0%	1.1%	1.1%
UK Manufacturing Output MM	0.2%	0.1%	1.1%

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
-	-	-	-

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
GE ZEW Current Conditions	18:00	-7.0	-10.2
GE ZEW Economic Sentiment	18:00	53.5	51.7
UK ILO Unemployment Rate	15:00	4.1%	4.1%
JP GDP QQ Annualized	7:50	5.8%	-3.6%
JP GDP QQ	7:50	1.4%	-0.9%

Шанхайн Фьючерсийн биржийн зэс 1.6% буурч 71,330 юань (\$11,217.88) боллоо.

### Газрын тосны зах зээл

ОХУ-аас Украин руу дайралт хийх өндөр магадлалтай байна гэж дэлхийн хэвлэл мэдээлэл шуугиснаар газрын тосны үнэ сүүлийн 7 жилийн хамгийн өндөр ханшийг тогтоолоо. Хэрвээ дайн болвол АНУ болон Европын холбооноос ОХУ-д хориг тавих, газрын тосны нийлүүлэлт улам хүндрэх нөхцөл байдал үүсэх юм. АНУ-аас гаргасан ОХУ дайралт хийх гэж байна гэж мэдээлсэн нь дэлхийн санхүүгийн зах зээлийг хүчтэй савлагаанд орууллаа.

### Бондын зах зээл

Даваа гарагт Японы Төв банк засгийн бондын өгөөжөө амжилттай барьж чадлаа. Төв банк зах зээлийг дэмжиж хүү өсөхөөс сэргийлнэ гэж мэдэгдсэний дараа, маш зөөлөн мөнгөний бодлогоо түр азнаснаар 10 жилийн засгийн өгөөж буурлаа. Өнгөрсөн долоо хоногт тус өгөөж өсөөд 0.23% хүрээд байсан бол 2 нэгж буурч 0.205% боллоо. Японы Төв банк бонд зарах санал байхгүй байсан учир ямар нэгэн худалдан авалт хийгээгүй гэж мэдэгдлээ.

### Хөрөнгийн зах зээл

Мөнгөний хатуу бодлогоос гадна ОХУ болон Украины маргаан хөрөнгө оруулагчдын санааг зовоож эхэллээ. Өнгөрсөн долоо хоногт S&P500 индекс 1.8%, Nasdaq 100 2.2% унасан бол Dow Jones хөдөлгөөн үзүүлсэнгүй. АНУ-ын зүгээс ОХУ Украин довтлоход бэлэн болсон гээд иргэддээ Украинаас гарахыг зөвлөсөн байна. Үүний дараагаар Жо Байден, Путин нар асуудлыг намжаахаар утсаар холбогдсон ч байдал дээрдээгүй байна.

### Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мэйлд хариу илгээнэ үү.